



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 1/26

Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг
хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 46 дугаар тогтоол, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, Авлигын эсрэг хуулийн 5, 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2026 оны авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулахыг нэгжийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж, хагас, бүтэн жилээр тайлагнаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажиллахыг Хуулийн хэлтэст даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1526010240



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
ерөнхий газрын даргын 2026 оны 01 сарын
22 өдрийн дугаар тушаалын хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хариуцах нэгж
2. Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ.				
2.5. Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.				
1	2.5.2. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.	2.5.2.1. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах	Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэл	Бүх нэгжүүд
2.6. Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.				
2	2.6.2. Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж хэвшүүлнэ.	2.6.2.1. Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлан төлөвлөгөө хэрэгжүүлэх	Тухайн яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын Шударга байдлын үнэлгээний онооны өсөлт	Бүх нэгжүүд
3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ.				
3.2. Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх болон хэрэгжилтийг үнэлэхэд иргэн, иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого, шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлнэ.				
3	3.2.3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголыг зохион байгуулахдаа иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.	3.2.3.2. Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголд иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	Сонсголд оролцсон ажиглагч, оролцогчдын тооны өсөлт	Бүх нэгжүүд
3.3. Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно.				

4		3.3.1.1. Иргэний байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн ажлын хэсэгт ажиллах иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тоог нэмэгдүүлэх	Хуулийн ажлын хэсгийн нийт гишүүдийн тоонд эзлэх иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл	Бүх нэгжүүд
5	3.3.1. Иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэхдээ баримт, судалгаа, зөвлөмжийг үндэслэн тэдгээрийн бодит оролцоог хангана.	3.3.1.4. Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	Бүх нэгжүүд
6		3.3.1.5. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавхжуулах	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд Олон нийтийн хяналтын үйл ажиллагаа	Бүх нэгжүүд
3.4. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлнэ.				
7	3.4.3. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээллийн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг баталж, мөрдүүлнэ.	3.4.3.2. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан нийт гэрээ, төлбөрийг ил тодоор нийтлэх журам, стандартын хэрэгжилтийг бүрэн хангах	Журам, стандартын хэрэгжилт	Бүх нэгжүүд
4. Хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.				
4.2. Шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа авлигын хүчин зүйлсийг арилгана.				
8	4.2.4. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах хангана.	4.2.4.8. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд олон улсын байгууллагаас шаардах Комплаенсын шаардлагыг хангах зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдэд ISO 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцоог нэвтрүүлэх	Стандарт нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхээр ажиллаж байгаа хуулийн этгээд	Бүх нэгжүүд
6. Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.				

6.4. Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.				
9	6.4.11. Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулна.	6.4.11.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах	Авлигын эсрэг ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	Бүх нэгжүүд
7. Төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулна.				
7.1. Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ.				
10	7.1.2. Төсвийн тухай хуульд төсвийн орлого, зарлагын мэдээллийг төсөв захирагчдаар нийтлэхээс гадна эдийн засгийн болон зориулалтын ангиллаар тооцон тусгана.	7.1.2.1. Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар харуулах тусгах	Төсвийн байдлын олон улсын судалгааны төслийн баримт бичгийн агуулгын үзүүлэлт	Бүх нэгжүүд
11		7.1.2.2. Төсвийн тухай хууль дахь төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч гэсэн ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох нэр тус бүрээр ил тод, тодорхой мэдээлэх	Төсвийн байдлын олон улсын судалгааны төслийн баримт бичгийн агуулгын үзүүлэлт	Бүх нэгжүүд
9. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.				
9.5. Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.				
12	9.5.2. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.	9.5.2.1. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	Зохион байгуулсан арга хэмжээ	Бүх нэгжүүд